



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/53

Хэрлэн сум

**Авлигын эсрэг сургалт зохион
байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах, мөн төрийн байгууллагуудад соён гэгээрүүлэх, байгууллагын дарга нарт авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэлийг бий болгох арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

Ахлагч:

Г.Тэмүүжин

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Нутгийн захиргааны байгууллагын бодлого тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

М.Шаравгаваа

Хууль эрх зүйн хэлтсийн Хууль тогтоомжийн мэдээлэл системчлэл дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Ж.Энхбат

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Компьютер, мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн

Ш.Эрдэнэжаргал

Хүний нөөц, агентлаг хариуцсан мэргэжилтэн

Б.Энх-Уянга

Нутгийн захиргааны нэгж, Төрийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

2. Авлигын эсрэг сургалтын ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, удирдамж гарган батлуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн (Г.Тэмүүжин)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА